



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1629 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 5,500,000 (таван сая таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэгдэл өртөггүй 1 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэст, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.МӨНХБАЯР

1150500035

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2024 оны 01 дугаар сарын 18-ний өдрийн
А/06... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгсэл

№	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн он, Монголд ашиглаж эхэлсэн оно	Арлын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Сэлбэг буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах доод үнэ (төгрөг)
1	2	3	4	5	6	7	8	9
1	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	Хьюндай соната-6 19-39 УБУ	2006/2010	КМННУ41ВРГА222418	5,500,000	2,426,409	3,073,591	350,000
Дүн					5,500,000	2,426,409	3,073,591	